



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 9 сарын 04 өдөр

Дугаар 128

Төрийн ордон, Улаанбаатар хот

### Г Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай.

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангах асуудлаар Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1, 111.2, 111.3 дахь хэсгийг хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудад чиглэл болгох;

2. “Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолын хавсралтад хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах орон тоог аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилчдын 25 хүн тутамд 1 гэж, Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймагт сар бүр төлөх төлбөрийн хэмжээг тухайн байгууллагын ажиллагсдын дундаж цалингийн хэмжээгээр, бусад аймагт тухайн байгууллагын ажиллагсдын дундаж цалингийн 60 хувиар гэж тус тус тогтоон мөрдүүлэх;

3. Аж ахуйн нэгж байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын оролцоог тэгш хангасан Үндэсний хороог байгуулж, санд төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих дүрэм журмыг баталж мөрдүүлэх;

4. Энэ зарлигийн хэрэгжилтийн талаар 2018 оны намрын чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд танилцуулах;

Хоёр. Энэ зарлигийг 2018 оны 09 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ


МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ХАЛТМААГИЙН БАТТУЛГА

УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ

ХУУЛБАР ҮНЭН  
Тамгын газрын дэд дарга

Г.Байгалмаа



0000000501